

ШУА-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЭНХТҮВШИН КЕМБРИЖИЙН ИХ СУРГУУЛЬД ЗОЧЛОВ

ШУА-ийн ерөнхийлөгч, академич Б.Энхтүвшин, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Д.Шүрхүү нар Их Британий Кембрижийн их сургуулийн Монгол, Дотоод Азийн судлалын төвийн урилгаар 3-р сарын 18-20-ны өдрүүдэд тус их сургуульд зочиллоо. Айлчлал 3 гол зорилготой байсны хамгийн гол зүйл бол манай ШУА дэлхийн шилдэг их сургуулийн нэг Кембрижийн их сургуультай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, одоо хэрэгжүүлж буй хамтарсан төслүүд, тухайлбал 2013 оны 7-р сарын сүүлчээр манай ШУА, Дэлхийн төвд судлалын холбоо, Кембрижийн их сургуультай хамтран Улаанбаатар хотноо зохион байгуулах Төвд судлалын 13-р их хурлын бэлтгэлийг хангах асуудлыг хэлэлцлээ. 2-рт, 2013 онд тохиож буй Монгол Британий хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн түүхт ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал, хоёр орны эрдэмтэд хамтран туурвисан “ТИВ ДАМНАСАН ХӨРШҮҮД” номын нээлтэд оролцлоо. 3-рт, Их Британи болон Кембрижийн их сургууль дээр монгол судлалыг хөгжүүлэн бэхжүүлэх асуудлаар санал солилцлоо. Хэдийгээр айлчлалын цаг бага, хөтөлбөр шахуу байсан боловч нэлээд зүйлийг амжуулж, айлчлал их үр дүнтэй болов.

Монгол-Британий шинжлэх ухааны хамтын ажиллагаа нэлээд эртнээс эхэлсэн билээ. Тухайлбал, ШУА-ийн анхны ерөнхийлөгч Б.Ширэндэв гуай Монгол-Британий шинжлэх ухааны хамтын ажиллагааны үндэс суурийг тавьж, улмаар социалист орнуудын эрдэмтдээс бараг анх удаа 1970 онд Лийдсийн их сургуулийн хүндэт докторын цолыг хүртэж байсан нь Монголын эрдэмтдийг өрнөдөд үнэлж эхэлсэнийг нотлох сайхан баримт юм. Мөн 1960-70-аад онд Б.Ширэндэв гуай нэрт монголч эрдэмтэн О.Латтимор, Ө.Онон нартай олон удаа захидлаар харилцаж байв. Энэ бүх баримтыг дээр дурдсан “Тив дамнасан хөршүүд” номын эхний ботиос үзэж болно. Тэгэхлээр манай ШУА, Британий их сургуулиуд, монголч эрдэмтэдтэй нягт хамтран ажиллаж ирсэн сайхан уламжлалыг үргэлжлүүлэн хөгжүүлэхэд Б.Энхтүвшин ерөнхийлөгчийн айлчлал чухал түлхэц өглөө.

Сүүлийн жилүүдэд ШУА-ийн нийгмийн ухааны хүрээлэнгүүд Кембрижийн их сургуультай хамтын ажиллагаагаа сэргээн хөгжүүлж, цаашид улам өргөжин тэлэх сайхан төлөв харагдаж байна. Британи

дахь манай ШУА-ийн албан ёсны төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэж буй Кембрижийн их сургуулийн доктор Урадын Э. Булагийн хичээл зүтгэл энд их байна. Зарим тодорхой жишээ дурдвал манай Түүхийн хүрээлэн Кембрижийн Их сургуулийн Нийгмийн антропологийн салбар, Монгол ба Дотоод Ази судлалын төвтэй хамтран “Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн” 10 боть эрдэм шинжилгээний тайланг 2011 онд хэвлүүлж, Олон улс судлалын хүрээлэн төмөр замын түүх, геополитикийн чиглэлээр хамтарсан төслийг 2013 оноос хэрэгжүүлж эхлээд байна. О.Батсайхан, С.Чулуун, Ц.Цэцэнбилэг, Д.Шүрхүү, Д.Золбоо зэрэг олон докторууд Кембрижид зочин судлаачаар ажиллалаа. Хамгийн сүүлийн нэг үр дүн бол Монгол-Британий харилцааны 50 жилийн ойд зориулан манай хоёр байгууллагын эрдэмтэд хамтран “Тив дамнасан хөршүүд” хоёр боть номны эхний дэвтрийг эрдэм шинжилгээ, чанарын өндөр түвшинд хэвлэн гаргав. Ойрын үед ШУА, Кембрижийн их сургуультай хамтран гүйцэтгэх нэг томоохон ажил бол Олон улсын төвд судлалын холбооны XIII их хурлыг амжилттай зохион явуулах үүргийг бид хүлээж байна. Дэлхийн олон арван орноос 500 орчим нэртэй эрдэмтэн, профессорууд анх удаа Улаанбаатар хотод хуран чуулах юм. Монголын шинжлэх ухааны түүхэнд хамгийн олон орноос хамгийн олон төлөөлөгчид оролцсон эрдэмтдийн том чуулга уулзалтыг Монгол Улс хүлээн авах гэж буй тул эртнээс маш сайн бэлтгэх хэрэгтэйг хоёр тал сайтар ойлгон шаргуу ажиллаж байна.

Хурлын бэлтгэл ажлын хувьд дотоод гадаадын хамтран ажиллаж буй байгууллага Кембрижийн их сургууль, МУИС, Дэлхийн төвд судлалын холбоо, Монголын төвд судлалын холбоо, Гандан хийд болон янз бүрийн байгууллага, хувь хүмүүсийн хүч дэмжлэгээр нэлээд ажлыг хийж гүйцэтгэжээ. Гэхдээ 500 гаруй гадаадын зочдыг Монголын аялал жуулчлалын оргил үе болох 7-р сард хүлээж авна гэдэг амаргүй ажил гэдгийг хаа сайгүй сайн ойлгож, одооноос бүх талууд ихэд хичээж байна. Энэ удаагийн айлчлалын үеэр Кембрижийн их сургуулийн Монгол, Дотоод Азийн судлалын төвийн захирал доктор хатагтай Х.Диймбергер болон доктор Урадын Булаг, Д.Снийт нартай энэхүү хурлын бэлтгэл ажлын талаар нухацтай хэлэлцэж, цаашид хийх ажлууд сайтар тохиролцоод ирлээ.

Төвд судлалын XIII их хурлыг Монгол Улсад зохион байгуулах эрхийг олгосон нь нэлээд олон талыг бодолцсон гэдгийг хэлмээр байна. Монгол Улс бол буддын шашинтай нээлттэй, ардчилсан орон

төдийгүй төвд судлалд Монголын эрт эдүгээгийн бичгийн их хүмүүс ихээхэн хувь нэмрийг оруулсан баялаг уламжлал, өвөрмөц түүх соёлтой орон билээ. Төвд судлал нь монгол судлал, монголын утга соёлын судлалын салшгүй нэг хэсэг юм. Учир нь монголчууд зуу зуун жил төвд хэлээр дамжуулан буддын ухаан, буддын шашин соёлыг үзэж, өөрсдийн ахуй соёлд суулган идээшүүлж, олон ном судрыг төвд хэлээр туурвижээ. Төвд хэлт шашин соёл нь монголчуудад нөлөөлсөн төдийгүй, эргээд төвд болоод буддын шашин соёлд монголчууд нэлээд нөлөөллийг үзүүлсэн юм. Тийм ч учраас төвд судалдаг хүн бүр Монгол орныг өөрийн биеэр үзэх, манай номын сан, архивуудад хадгалагдаж буй төвд ном судар, сурвалж бичгүүдтэй танилцахыг хүсдэг юм. Манай талаас ч Монгол дахь буддын шашин соёл, төвд судлалын өв уламжлал болон улс орныхоо хөгжил дэвшил, түүх соёлыг дэлхий дахинд сурталчлан таниулах, манай төвд судлаачид дэлхийн төвд судлалын нэртэй эрдэмтэдтэй ойртон танилцах, төвд судлалыг эрчимжүүлэх ач холбогдлыг чухалчлан үзсэн билээ.

ШУА-ийн төлөөлөгчдийн айлчлалын нэг гол зорилго бол Монгол-Британий хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойд зориулсан “Монголын эрдэс баялгийн стратегийн геополитик болон геоздийн засгийн асуудлууд” сэдэвт олон улсын симпозиумд оролцох явдал байлаа. Энэхүү хурал маань үндсэндээ Монголын эрдэс баялаг, байгаль хамгаалал, Монгол-Британий харилцаа гэсэн 3 том асуудлыг нэг дор хэлэлцсэн байдлаараа, оролцсон төлөөлөл болон эрдэм шинжилгээний түвшингийн хувьд үнэхээр өндөр түвшинд болсон юм.

Тус хуралд Монголоос бид хоёроос гадна УИХ-ын гишүүн Р.Амаржаргал, Британи дахь Монголын ЭСЯ-ны ажилтнууд, Монголын экспортлогчдын холбооны ерөнхийлөгч Д.Галсандорж, Монгол банкны Лондон дахь төлөөлөгч Д.Энхжаргал, тэнд ажиллаж сурч буй монголчууд оролцов. Гадаадын төлөөлөгчдийн хувьд Их Британий эрдэмтдээс гадна Дани, ОХУ, БНХАУ, Япон зэрэг орнуудаас маш өндөр түвшний эрдэмтэн судлаач мэргэжилтнүүд төдийгүй Рио Тинто, эрчим хүчний хувийн компаний төлөөлөл илтгэл тавив. Бараг анх удаа Монголын эрдэс баялгийн улс төр, эдийн засаг, экологи, нийгмийн олон талт асуудлыг улс төрчид, хөрөнгө оруулж буй компаниуд, нэр хүндтэй доктор профессорууд хамтдаа нухацтай хэлэлцлээ. Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт, нүүдлийн, хөдөө аж ахуйн нийгмээс эрдэс баялагт тулгуурласан ардчилсан, нээлттэй аж үйлдвэрийн нийгэм рүү шилжихэд ямар асуудал бэрхшээл, ямар ололт амжилт байгааг бодит жишээ баримт

дээр тулгуурлан ярьж байлаа.

Хурлын бас нэг сонирхолтой хэсэг бол Монгол Улс 1963 онд өрнөдийн орнуудаас хамгийн түрүүнд Их Британитай дипломат харилцаа тогтоосон түүх, уламжлалыг өнөөгийн хүрсэн түвшинд, цаашдын хөгжлийн боломж потенциалыг хэлэлцсэн явдал байлаа. Уг хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн Р.Амаржаргал, Монголын ЭСЯ-ны Хэргийг түр хамаарагч Н.Батаа, Рио Тинтогийн Гадаад харилцаа эрхэлсэн захирал Р.Соурт, Монгол-Британий худалдааны танхимын дарга Ж.Гроган, Кембрижийн их сургуулийн Жарж Бизнес сургуулийг үүсгэн байгуулагчдын нэг Сэр П.Жарж, бие даасан монгол судлаач А.Сандерс зэрэг янз бүрийн нийгмийн бүлгүүдийн төлөөлөл илтгэл тавив. ШУА-ийн ерөнхийлөгч Б.Энхтүвшин Монгол-Британий шинжлэх ухааны салбар дахь хамтын ажиллагаа, доктор Д.Шүрхүү Монголын шинэ төмөр замын бүтээн байгуулалт ба геополитикийн ба бизнесийн ашиг сонирхлын зөрчил гэсэн сэдвээр тус тус илтгэл тавьж оролцлоо.

Манай төлөөлөгчдийн өөр нэг зорилго бол ШУА-Кембрижийн их сургуулийн Монгол, Дотоод Азийн судлалын төвийн хооронд ойрын жилүүдэд хамтран ажиллах асуудлыг хэлэлцэх явдал байв. Хоёр тал ойрын 5 жилд хамтран ажиллах тухай Санамж бичиг байгуулж, Монгол судлалын чиглэлээр эрдэмтэн солилцох, хамтарсан судалгаа явуулах, ном, сэтгүүл, мэдээлэл солилцохоор тохиролцлоо. Хоёр тал хамтарсан судалгааны төвийг ШУА-ийг түшиглэн байгуулж, эрдэм шинжилгээний номын сангийн салбарт хамтран ажиллах талаар ч ярилцав.

Кембрижийн их сургуулийн Монгол, Дотоод Ази судлалын төв бол анх Өргөнгөө Онон, Каролайн Хамфри нарын санаачлагаар 1986 онд байгуулагдсан Европ дахь Монгол судлалын томоохон төв юм. Тус төв К.Хамфри, Х.Диенбергер, Д.Снийт, Урадын Булаг зэрэг үндсэн 4-5 ажилтан, 4-5 хавсран гүйцэтгэх судлаачид бүхий цомхон бүтэцтэй боловч сүүлийн 10 гаруй жилд маш олон төсөл хөтөлбөр, хурал семинар, ном бүтээлүүд туурвисан байна. Британи бол шинжлэх ухаан өндөр хөгжсөн, их дэмждэг орон тул тус төвийн эрдэмтэд янз бүрийн шугамаар томоохон төслийн санхүүжилт авдаг. Жишээ нь профессор К.Хамфри Дотоод Азийн байгаль орчны чиглэлээр 500 мянган долларын, доктор Д.Снийт Монголын аман түүхийн чиглэлээр 700 мянган фунтын төслийг тус бүр 3 жилийн хугацаатай аваад хэрэгжүүлсэн байна. Зөвхөн нэг төсөл нь манай ШУА-ийн жилийн эрдэм шинжилгээний зардлаас 2-2.5 дахин их байна.

Гэхдээ сүүлийн үед Монголын төр засгийн зүгээс дотоод, гадаадын монгол судлалыг хүчтэй дэмжихгүй бол Европ дахь Монгол судлалын төвүүд, судалдаг эрдэмтдийн тоо жилээс жилд цөөрсөөр байна. Иймд ШУА-ийн зүгээс Кембриж дэх монгол судлалын энэ гал голомтыг чадлын хэрээр дэмжих, нягт хамтран ажиллах нь зүйтэй хэмээн үзэж байна. Энэ удаагийн айлчлалаар бид нар ШУА-ийн хүрээлэн, төвүүдийн хамгийн сүүлийн ном бүтээлүүд 100 гаруй ном, сэтгүүлийг бэлэглэлээ. Британий монголч эрдэмтэд манай засгийн газраас Монгол судлалын сан байгуулж, ойрын жилүүдэд 8.7 тэрбум төгрөг зарцуулах талаар шийдвэр гаргасныг их итгэл төрүүлсэн сайхан мэдээ гэж байлаа.

Бид нар хурлын завсар чөлөөгөөр Кембрижийн их сургуулийн номын сантай товчхон танилцлаа. Уг номын сан Их Британидаа Лондонгийн номын сангийн дараа 2-рт ордог, одоогоор фонд нь 8 сая номтой, жил бүр номын тавиур нь 3км-ээр нэмэгддэг юм байна. Бидний анхаарал татсан нэг зүйл бол Япон, Хятад, Солонгос зэрэг орнууд өөрийн зардлаар орон судлалын тусгай фонд байгуулж бэлэглэжээ. Тэгэхлээр өдөрт хэдэн арван мянган хүн үйлчлүүлж буй энэ том номын санд дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн судлаачид, профессор, оюутнууд эдгээр орны сурвалж бичиг, судалгааны зохиолуудыг уншиж судлах бүрэн боломжтой болсон байна. Монгол улс ч тодорхой зардал төсвөө гаргаад Кембрижийн номын сан дотор монгол судлалын ном, хэвлэлийн сан хөмрөг байгуулбал ШУА болон Монголын бүх эрдэмтдийн бүтээл дэлхий нийтэд хүрэх том үүд хаалга нээгдэх боломжтой. ШУА-ийн зүгээс жил бүр шинэ гарсан ном бүтээлүүдээ байнга илгээж байхаар тохирлоо.

Мэдээ бэлтгэсэн Д.Шүрхүү
Кембриж, 2013 оны 3-р сар